



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 9/155.

Зуунмод

Хичээл сургалтын үйл ажиллагааг  
хэсэгчлэн эхлүүлэхтэй холбогдуулан авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Улсын Онцгой Комиссын 2021 оны “Түр журам батлах тухай” 18 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/140, 2021 оны А/58 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны А/129, А/146 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуулийн танхимиын сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой КОВИД-19 цар тахлын халдварт тархалт, түүнээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын эрсдэлийн үнэлгээ”, Цэцэрлэг, сургуулийн орчны халдвартын үеийн бэлэн байдлыг үнэлэх асуумжийн үр дүнг үндэслэн, өндөржүүлсэн бэлэн байдлын үед аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Зуунмод сумаас бусад сумдын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 1-11 дүгээр ангийн танхимиын сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлсүгэй.

2. Танхимиын сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/58 дугаар тушаалаар батлагдсан “Түр журам”-ыг хэрэгжүүлэн, хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Цэцэрлэгийн эрхлэгч, Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар (Р.Ундрахбаяр)-т тус тус даалгасугай.

3. Цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчнөөс сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, сургалтын үйл ажиллагааны явцад халдварт хамгаалалын дэглэм мөрдүүлэх, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэгийг тухай бүрт үзүүлж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга бөгөөд онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хийсэн эрсдэлийн үнэлгээ, бэлэн байдлын асуумжаар цэцэрлэг, сургуульд “Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан бие даасан орон тоогоор ажилладаггүй” гэж үнэлэгдсэн тул мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг сумдын Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд түр журмыг хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээний багийн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т, халдварт хамгааллын дэглэм мөрдүүлэх үйл ажиллагаанд мэргэжил арга зүйгээр ханганд, ковид-19 цар тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБААТАР

